



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/18

Мандалговь

Орон тооны бус байнгын комисс  
шинэчлэн томилох тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2015 оны 269 дугаар тогтоолоор батлагдсан Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг үндэслэн ТУШААХ нь:

1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг шинэчлэн дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, хөрсний доройтол (Цөлжилт), байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Мэдээллийн сан, байгаль орчны төлөв байдал, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн  
Биологийн төрөл зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн

2. Засгийн газрын 2015 оны 269 дугаар тогтоолоор батлагдсан Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг судалж, хуулийн дагуу ажиллахыг комиссын ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2015 оны А-25 дугаар тушаалыг хүчингүй болсон тооцсугай.

ДАРГА  Н.ГАНТУЛГА



482301094